

**"ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААНЫ ХӨТӨЛБӨР"-ИЙН
ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ**

2022.12.06

№	№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Мөнгөн дүн	Хамрах хүрээ	Зохион байгуулах байгууллага
Нэг: Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийн “Төрийн албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүн, ур чадвар, санал санаачилгыг харгалзан цалин хөлс, урамшууллын тогтолцоог бүрдүүлэх зорилтын хүрээнд”						
1.	1.1	Албан хаагчид олгох үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдлийн хэмжээг холбогдох хууль тогтоомжийг үндэслэн тогтоох	Тухай бүр		<ul style="list-style-type: none">2021 оны ажлын гүйцэтгэлийн үнэлгээг үндэслэн Газрын даргын 2022 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн Б/01 дүгээр тушаалаар 16 албан хаагчдын цалингийн шатлал ахиулах асуудлыг шийдвэрлэсэн.Барилга, хот байгуулалтын Сайдын 2022 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 66 дугаар тушаалыг үндэслэн Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв олгогдсон 13 албан хаагчдад тус газрын даргын 2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн Б/40 дүгээр тушаалаар зэрэг дэвийн нэмэгдлийг тооцон олгосон.Засгийн газрын 2022 оны 192 дугаар тогтоолыг үндэслэн Төрийн үйлчилгээний албан хаагчдын цалингийн доод жишигийг нэмэгдүүлэн батлагдсантай холбогдуулан төсөвт холбогдох зардлыг суулгуулан төрийн үйлчилгээний албан хаагч нарын цалинг нэмэгдүүлэн олгож байна.Төрийн жинхэнэ албан хаагчийн 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг бүх албан хаагчдаас гаргуулан авч, 2022.01.10-ний өдөр нэгжийн дарга нараар батлуулан авсан.1-р улирлын гүйцэтгэлийн тайланг 2022.03.30-ны өдрөөр гаргуулан авч нэгжийн дарга нарын өгсөн ярилцлагын үнэлгээг хянаж нэгтгэн Газрын даргын A/86 дугаар тушаалаар A, В үнэлгээ авсан 73 албан хаагчдад мөнгөн урамшуулал олгосон. 21,511,045 төгрөг зарцуулсан.2-р улирлын гүйцэтгэлийн тайланг 2022.06.10-ны өдрөөр гаргуулан авч нэгжийн дарга нарын өгсөн ярилцлагын үнэлгээг хянаж нэгтгэн Газрын даргын A/145 дугаар тушаалаар A, В үнэлгээ авсан 68 албан хаагчдад мөнгөн урамшуулал олгосон. 20,759,781 төгрөг зарцуулсан.	
2.	1.2	Албан хаагчид улирлын ажлын үр дүнг үнэлж, дүгнэн мөнгөн урамшуулал олгох	Улирал бүр			

3. 1.3	Төрийн онцгой чухал буюу онц түвэгтэй албан даалгавар биелүүлсэн, төрийн байгууллагын үйл ажиллагаа, төрийн үйлчилгээг сайжруулах чиглэлээр шинэ санал, санаачилга гаргаж хэрэглээнд нэвтрүүлсэн төрийн албан хаагчдыг шагнаж урамшуулах, Засгийн газрын болон төрийн дээд шагналд тодорхойлох, шагнал гардуулах хүндэтгэлийн арга хэмжээг зохион байгуулах	Тухай бүр	4,622,280		<ul style="list-style-type: none"> 3-р улирлын гүйцэтгэлийн тайланг 2022.09.30-ны өдрөөр гаргуулан авч нэгжийн дарга нарын өгсөн ярилцлагын үнэлгээг хянаж нэгтгэн Газрын даргын A/174 дүгээр тушаалаар А, В үнэлгээ авсан 68 албан хаагчдад мөнгөн урамшуулал олгосон. 20,759,781 төгрөг зарцуулсан. 4-р улирлын гүйцэтгэлийн тайланг 2022.12.05-ны өдрөөр гаргуулан авч нэгжийн дарга нарын өгсөн ярилцлагын үнэлгээг хянаж нэгтгэн А, В үнэлгээ авсан албан хаагчдад мөнгөн урамшуулал олгосон. Төрийн байгууллагын үйл ажиллагаа, төрийн үйлчилгээг сайжруулах чиглэлээр шинэ санал, санаачилга гарган ажиллаж буй төрийн албан хаагчдыг 5 албан хаагчийг “Газрын харилцааны тэргүүний ажилтан” хүндэт тэмдгээр, 3 албан хаагчийг БХБЯ-ны “Жуух бичиг”-ээр шагнуулахаар уламжлан шийдвэрлүүлсэн. Мөн 3 албан хаагчийг агентлагийн “Жуух бичиг”-ээр тус тус шагнуулах ажлыг зохион байгуулсан. Төрийн дээд одон медалиар 8 албан хаагч шагнагдсан бөгөөд албан хаагчдад дагалдаа мөнгөн олговорыг Газрын даргын тушаалаар тус тус олгосон. ГЗЗХ-ийн ахлах мэргэжилтэн Л.Золзаяа Бээжингийн Агаар Сансырын Их Сургуулийн “Газарзүй мэдээллийн систем-Зайнаас тандан судлал” мэргэжлээр магистрантад, Хот байгуулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн А.Энхнаран Удирдлагын академийн Удирдахуйн Ухааны Төрийн удирдлагын гарагийн ангид 45 хоногийн хугацаагаар тус тус суралцаж байна. Дээрх албан хаагчдад цалинтай чөлөө олгон дэмжлэг үзүүлсэн. БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны агентлаг /КОЙКА/-аас зохион байгуулж байгаа “Urban and Regional Development” сэдэвт магистрын сургалтад Хот байгуулалтын кадастрын хэлтсийн дарга Х.Оюунбаяр, Хот байгуулалтын кадастрын хэлтсийн Эдийн засаг, хөрөнгө оруулалт, нийгмийн дэд бүтцийн судалгаа, мэдээллийн сан хариуцсан мэргэжилтэн Э.Ганчулуунд Япон Улсын Сайтамагийн Их сургуульд суралцахад дэмжлэг үзүүлсэн.
4. 1.4	Албан хаагчийн оюуны бүтээл болон бүтээлч санал санаачилгыг дэмжих, албан хаагч байгууллагын болон өөрийн зардлаар мэргэжил эзэмших, мэргэшүүлэх сургалтад хамрагдах, магистр, докторантурт суралцах тохиолдолд дэмжлэг үзүүлэх	Тухай бүр			

Хоёр: Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийн

“Албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэж тусламж, тэтгэмж, дэмжлэг, нөхөн олговор олгох зорилтын хүрээнд”

5.	2.1	Албан хаагч нь эрүүл мэндийн шалтгааны улмаас өвдөж, эмчлүүлэх тохиолдолд санхүүгийн тусlamж үзүүлэх	Тухай бүр	2,500,000	Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын дагуу тусlamж 5 албан хаагчид олгосон.
6.	2.2	Албан хаагчийн ахуй амьдрал, ар гэрт гачигдал тохиолдвол буцалтгүй тусlamж үзүүлэх	Тухай бүр	1,500,000	Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын дагуу буцалтгүй тусlamж 5 албан хаагчид олгосон.
7.	2.3	Албан хаагч өндөр насны тэтгэвэр, эрдмийн зэрэг цол хамгаалсан, 50 нас хүрсэн тохиолдолд хүндэтгэл үзүүлэх	Тухай бүр	1,000,000	Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын дагуу өндөр насны тэтгэвэрт гарсан 1 албан хаагч, 50 нас хүрсэн 1 албан хаагчид хүндэтгэл үзүүлэх ажлыг зохион байгуулсан.
8.	2.4	Албан хаагч гэрлэх, хүүхэдтэй болох, хүүхэд үрчлэн авах, хурим хийхэд хүндэтгэл үзүүлэх, чөлөө олгох	Тухай бүр	800,000	Газрын даргын тушаалаар шинээр хүүхэдтэй болсон 4 албан хаагчид 10 өдрийн цалинтай чөлөө олгож, 200000 төгрөгийг тус тус олгосон байна.
9.	2.5	Албан хаагчид сар бүр унаа, хоолны мөнгөн олговорыг тооцож олгох	Тухай бүр	172,260,00	Албан хаагчдад унаа, хоолны хөнгөлөлт 8000 төгрөгөөр, 11 сарын 01-ний өдрөөс 15000 төгрөгөөр тус тус тооцон олгож байна.
10.	2.6	Албан хаагчдыг ажлын зайлшгүй шаардлагаар долоо хоногийн амралтын өдөр, нийтээр амрах баярын өдөр илүү цагаар ажиллуулсан бол албан хаагчийг ажлын өдөр нөхөн амруулах эсхүл Хөдөлмөрийн тухай хуульд заасан нэмэгдүүлсэн цалин хөлс олгох	Жилдээ	5,600,000	Улсын Их Хурлын 2021 оны "Шинэ сэргэлтийн бодлого" батлах тухай тогтоолын 5 дугаар хавсралтаар батлагдсан Монгол Улсын Их Хуралд 2022 онд үе шаттайгаар өргөн мэдүүлэх жагсаалтын 16-д туссан Газрын багц хуулийн төслүүдийг Засгийн газарт өргөн барих, эцэслэн боловсруулах, хэлэлцүүлэх, шаардлагатай судалгааг гаргах үүрэг бүхий албан хаагч наарт 5,472,300 төгрөгийн илүү цагийн нэмэгдэл хөлс олгоод байна. Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын 101 жилийн ойн баярын өдруүдэд хариуцлагатай жижүүрийн үүрэг гүйцэтгэсэн 5 албан хаагчид хуулийн дагуу 463728 төгрөгийн нэмэгдэл цалин хөлс олгосон.
11.	2.7	Ээлжийн амралтаараа өөрийн, эсхүл эхнэр (нөхөр)-ийн төрсөн нутагт явсан бол ирэх, очих замын зардлыг эсхүл дотоодын сувилаалд сувилуулсан бол ирэх, очих замын зардлыг олгох.	Жилдээ		Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12.1.2-т "ээлжийн амралтаараа дотоодын амралт, сувилалын газарт, эсхүл өөрийн болон эхнэр /нөхөр/-ийн төрсөн нутагт амрах тохиолдолд түүний очих, ирэх замын зардал" санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно гэж заасан.
12.	2.8	Төрийн албан хаагчид өвлийн улирлын бэлтгэлээ хангахад зориулж нөхөн төлбөр олгох	III-р улирал	1,250,000	Тус газрын даргын тушаалаар гэр болон галлагатай байшинд амьдардаг 5 албан хаагчид өвлийн улирлын бэлтгэлээ хангахад зориулж тус бүр 250,000 төгрөгөөр тооцон нөхөн олговор олголоо.
13.	2.9	Агентлагийн албан хаагчдад зуслангийн зориулалтаар олгосон газарт тохижилт, дэд		2,500,000	Байгууллагын албан хаагчдын зуслангийн газар жимс жимсгэнэ моджуулах ажлын хүрээнд чацарагын мод 1000 ширхэг, нарс мод

	бүтэц, төлөвлөлтийн асуудлыг шийдвэрлэж, дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулах	II-р улирал	50 ширхэг тарьж, усалгаа болон арчилгааг хийж байна. Намрын мод тарих ажлыг 2022.10.14-ний өдөр зохион байгуулж, 300 мод тарьж, услалтыг хийсэн.
14. 2.1	Агентлагийн албан хаагчдад хөнгөлөлттэй үнээр орон сууц бариулах, байрыг ашиглалтад оруулах ажлыг зохион байгуулах	Жилдээ -	Барилгын ажилд захиалагчийн хяналт тавих “Ажлын хэсэг”-ийг байгуулан хяналт хийж байна. Нийт албан хаагч болон гүйцэтгэг компанийн төлөөлөлтэй барилгын ажлын явцын талаар 2 удаа уулзалт зохион байгуулсан.
Гурав: Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийн “Салбарын албан хаагчдын ажиллах нөхцөл бололцоог орчин үеийн шаардлагад нийцүүлэн сайжруулах зорилтын хүрээнд”			
Төрийн байргүй түрээсийн байр, ажлын байрны шаардлага хангахгүй байранд үйл ажиллагаа явуулж буй аймгуудын Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар болон Нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын албаны байрыг засварлах, шинээр байр барих газрын судалгаа хийж дараа оны улсын төсөвт тусгуулах саналыг БХБЯ-нд хүргүүлэх			
15. 3.1	Албан хаагчдын өрөө тасалгааг тохижуулах ажлын судалгааг гаргаж, холбогдох арга хэмжээ авах	Жилдээ -	2023 оны төсвийн төсөлд Сэлэнгэ, Говь-Сүмбэр, Дорнод, Дундговь аймгийн ГХБХБГ-ын байрыг шинээр бариулах саналыг тусган холбогдох дээд шатны байгууллагуудад Төсвийн тухай хууль, холбогдох журмын дагуу төлөвлөн хүргүүлсэн.
16. 3.2	Албан хаагчдын компьютер, багаж, тоног төхөөрөмжийн судалгааг гаргаж, холбогдох арга хэмжээ авах	Жилдээ 17,966, 040	Албан хаагчдын өрөө тасалгааг тохижуулах ажлын судалгааг гаргаж, 17,966, 040 төгрөгийн зардал гаргаж, ажиллах нөхцөлийг сайжрууллаа.
17. 3.3	Албан хаагчдын компьютер, багаж, тоног төхөөрөмжийн судалгааг гаргаж, холбогдох арга хэмжээ авах	Жилдээ 16, 957, 971	Албан хаагчдын компьютер, багаж, тоног төхөөрөмжийн судалгааг гаргаж, 16, 957, 971 төгрөгийн зардал гаргаж, ажиллах нөхцөлийг сайжрууллаа.
18. 3.4	Албан үүргээ гүйцэтгэж байх үед нь хүчирхийлэх, заналхийлэх, доромжлох, гүтгэх болон бусад хууль бус үйлдэл, үйл ажиллагаанаас төрийн албан хаагчийг хамгаалах	Жилдээ	Канадын Засгийн газрын санхүүжилтээр “Монгол Улсад мэргэжлийн, иргэн төвтэй төрийн албыг бэхжүүлэх нь” Монгол Улсын Төрийн албаны зөвлөл, НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр төслийн багтай байгууллагын ёс зүйн зөвлөл хамтран төрийн байгууллагын үр дүнг дэмжих хүний нөөцийн удирдлагыг төлөвшүүлэх, төрийн албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх суурь нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор сургалтыг 2022 оны 9 дүгээр сарын 23-ны өдөр зохион байгуулж, нийт 56 албан хаагчийг хамрууллаа.
Дөрөв: Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийн “Ажилтнуудын эрүүл мэндийг хамгаалах, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрүүл амьдрах дадал хэвшлийг төлөвшүүлэх зорилтын хүрээнд”			
19. 4.1	Албан хаагчдыг жилд нэг удаа эрүүл мэндийн урьдчилсан үзлэг, эмнэлгийн оношилгоонд	Жилдээ	Тус газрын удирдлагын санаачилгаар албан хаагчдыг хавдрын эрт илрүүлэг, үзлэгт хамруулахаар ХСҮТ-ийн удирдлагуудад санал

		хамруулах, холбогдох байгуулагуудтай хамтран ажиллах			тавьсны үндсэн дээр үзлэг, оношилгоог 11 сарын 26-ны өдөр зохион байгуулж, 70 албан хаагчийг хамрууллаа.
20.	4.2	Албан хаагчдын сэтгэл зүй, сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах аливаа өвчлөлийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор сэтгэл зүйчээс мэргэжлийн зөвлөгөө авах	Улирал бүр		Цаашид үзлэг, шинжилгээний нэгдсэн дүн гарсны дараа эмнэлгийн тусламж, эмчилгээ, үйлчилгээ үзүүлэх асуудлаар удирдлагын түвшинд ярилцаж шийдвэрлэхээр төлөвлөж байна.
21.	4.3	Албан хаагчдын гэр бүл, залуу гэр бүлийг дэмжих зорилго бүхий "Эцэг эхийн зөвлөл", "Соёл, спорт, эрүүл мэндийн зөвлөл"-ийг ажиллуулах, дэмжлэг үзүүлэх	Жилдээ		Сэтгэцийн болон сэтгэлзүйн сургалт, зөвлөгөөний төвтэй хамтран тус газрын нийт /65/ албан хаагчдад зориулан "Сэтгэл зүй, хувь хүний хөгжил" сэдэвт сургалтыг 2022 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр зохион байгуулсан. Хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Эцэг, эхийн зөвлөлийг шинэчлэн байгуулж, төлөвлөгөө батлан хэрэгжүүлэн ажиллаж байна. ЧД-ийн 9-р цэцэрлэгтэй хамтын ажиллагааны санамж бичиг байгуулан албан хаагчдын 5 хүүхдийг хамруулж, анги танхимыг тохижуулсан.
		Тав: Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийн "Албан хаагчдын сонирхол, хэрэгцээ, сэтгэл зүйн хандлагад нийцүүлж чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хамт огны эвсэг уур амьсгалыг бүрдүүлэх зорилтын хүрээнд"			
22.	5.1	Байгууллага, хамт огны дунд найрсаг, бие биенээ хүндэтгэсэн орчин, албан хаагчдын зөв харилцаа, хандлага, соёлыг төлөвшүүлэх, сайн туршлагыг дэмжих, дэлгэрүүлэх арга хэмжээг зохион байгуулах	Жилдээ		Эерэг хандлага, гүйцэтгэлийн оролцоо, баг бүрдүүлэх сэдвээр илтгэгч Н.Энхбаатарыг урьж нийт албан хаагчдад сургалт зохион байгуулсан. Нийт 69 албан хаагч оролцсон.
23.	5.2	Байгууллага, олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах үүрэг бүхий "Соёл, спорт, эрүүл мэндийн зөвлөл" ажиллах бөгөөд байгууллагын албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, чийрэгжүүлэх спортын арга хэмжээг зохион байгуулах	Жилдээ		Тус газрын даргын 2022.11.08-ны өдрийн Б/187 дугаар тушаалаар "Соёл, спорт, эрүүл мэндийн зөвлөл"-ийг шинэчлэн баталж, төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллаж байна. Байгууллагын албан хаагчдын дунд соёл, спортын арга хэмжээг 11 дүгээр сарын 10-12-ны өдрүүдэд 6 төрлеер нийт албан хаагчийн хамруулсан тэмцээнийг Хил хамгаалах еренхий газартай хамтран зохион байгуулсан. Мөн Барилга, хот байгуулалтын сайдын нэрэмжит салбарын байгууллагудын дунд зохион байгуулсан 4 төрелт тэмцээнд оролцож агентлаг багийн дүнгээр 2 дугаар байрт шалгарсан.
		Зургаа: Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийн "Албан хаагчийн гэр бүлийг дэмжих зорилтын хүрээнд"			
24.	6.1	Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийн хүрээнд "Эцэг эхийн зөвлөл", "Соёл, спорт, эрүүл мэндийн зөвлөл"-тэй хамтран хөгжөөнт арга хэмжээ зохион байгуулах	I-р улирал	156,800	Олон улсын эмэгтэйчүүдийн өдрийг тохиолдуулан тус газрын даргын тушаалаар 56 эмэгтэй албан хаагчдад мэндчилгээ хүргэж, хүндэтгэл үзүүлсэн байна.

25.	6.2	Эх үрсийн баярын өдрийг тохиолдуулан албан хаагчдын 0-16 хүртэлх насын хүүхдүүдэд бэлэг өгөх, гэр бүл, хүүхдүүдийн дунд уралдаан, тэмцээн зохион байгуулах.	II-р улирал		Эх үрсийн баярын өдрийг тохиолдуулан албан хаагчдын 0-16 хүртэлх насын хүүхдүүдэд зориулан 135 хүүхдийн бүртгэл, судалгааг гаргасан. Хүүхдийн өмнө үүрэг хүлээгчдийн үндэсний "Хүүхдэд ээлтэй Монгол" чуулган УИХ-ын гишүүн Б.Баярсайханы санаачилгаар зохион байгуулагдсан бөгөөд чуулганд хамрагдаж цаашид хүүхэд хамгааллын бодлого, чиглэлтэй танилцан, цаашид авах арга хэмжээний санал боловсруулан ажиллаж байна.
26.	6.3	Орон нутагтай хамтран зах зээлийн үнээс хямд жимс, хүнсний ногоо, сүү, цагаан идээгээр хангах ажлыг зохион байгуулах	Жилдээ	Албан хаагчдаас санал авч 1 сард зохион байгуулахаар төлөвлөсөн.	
27.	6.4	Байгууллагын туслах аж ахуйгаас үнэгүй мал, мах өгөх ажлыг зохион байгуулах	2 удаа Хэдэн хонь	Байгууллагын туслах аж ахуйгаас нийт албан хаагчдад 7 , 10 дугаар саруудад 2 албан хаагчийн дунд 1 хонь тус тус олгох ажлыг зохион байгуулсан.	